

Галт зэвсэг ашиглах сургалтыг сайжруулах арга зам

Б.Мөнхсайхан¹, П.Даваажав²

¹Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн,
Инновац, технологи дамжуулалтын төв

²Докторант

Key words:

Firearms, handling
and shooting
training, safety
of officer, virtual
interactive.

Abstract: The topic covers the origin, development, classification, and handling and shooting of firearms, as well as their application in various fields, particularly focusing on the training and preparation of personnel in military and law enforcement organizations. It addresses current trends, skill levels, and identifies outcomes from recent studies on improving and virtual interactive firearms training to ensure the safety of personnel.

Оршил

Хятадад хар дарийг IX зууны үед нээсэн үеэс анхны буу хэлбэртэй зүйл болох хулсан хоолойг дарь, чулуу, төмөр зэрэг зүйлээр цэнэглэн хол зайнд шидэж ашиглаж байжээ. Энэ зүйл нь XIII зууны эхэн хагаст дундад Ази, торгоны замаар дамжин Европт хүрч хөгжлийн тодорхой түвшин хүрсэн бөгөөд тэр үеийн анхны загвар хийцтэй галт зэвсгээс өнөө үеийн өндөр цэцтэй галт зэвсэг болон хөгжсөөр иржээ. Галт зэвсэгтэй холбоотойгоор чулуу, ширмэн төмөр, бусад металь сумнаас орчин үеийн буудлагын сум ч тодорхой түвшинд хүрч хөгжсөн байна.

Галт зэвсгийг хэдэн зуун жилийн туршид хүмүүс дайн, ан агнуур, өөрийгөө хамгаалах, цэрэг байлдааны үйл ажиллагаанд ашиглаж ирэв. Техник, технологи хөгжихийн хэрээр галт зэвсэг ч өөрчлөгдсөөр байна¹.

Галт зэвсгийн хөгжлийн үе шатаар нь ерөнхийд нь буудлагын зэвсэг, артиллери, миномёт, өөрөө явагч артиллери, зэрэг галладаг тийрэлтэт систем, танк эсэргүүцэх хэрэгсэл² гэж ангилдаг байна.

Буудлагын зэвсэг нь гар буу (энэ нь нэг гараар, мөр оролцохгүй буудах боломжтой, 40 см-ээс урт биш байх); карабин /урт буу/ (хоёр гараар, мөрний дэмжлэгтэй, гол төмрөөс гарах тийрэлтийг багасгасан, 41 см-ээс дээш урттай байх); шотган /гөлгөр гол төмөртэй/ (сумын төрөл нь өөр, хоёр гараар, мөрний тусламжтай буудлага үйлдэх, 45 см-ээс урттай буунууд) гэж ангилдаг байна³.

¹ <https://en.wikipedia.org/wiki/Gun#History>

² А.Хүү-Ухна “Зэвсэглэлийн түүх, орчин үе, хэтийн төлөв” Улаанбаатар 2015 он.

³ <https://www.pewpewtactical.com/types-of-guns/>

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийг судлан үзэхэд: 4.1.1.иргэний; 4.1.2.харуул хамгаалалтын; 4.1.3.хууль сахиулах албаны; 4.1.4.байлдааны⁴ гэж төрөлжүүлэн зааж өгсөн. Монгол Улсад буудлагын зэвсгийг батлан хамгаалах, хууль сахиулах, хувийн хамгаалалтын алба, спорт сургалт, ан агнуур, хувийн аюулгүй байдлаа хангах зорилгоор ашиглаж, эзэмшиж байна.

Нэг. Галт зэвсэг ашиглах сургалт бэлтгэлийн хэрэгцээ, шаардлага

Батлан хамгаалах, Хууль сахиулах салбарын алба хаагчдын галт зэвсэгтэй харьцах дадлага, ур чадварыг дээшлүүлэх, байнгын бэлэн байдлыг хангуулахын тулд тэдгээрийг үр дүнтэй тасралтгүй сургаж бэлтгэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын “Хүний аюулгүй байдлыг хангах” бодлогын хүрээнд олон улсын терроризм, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос урьдчилан сэргийлэх, хүн худалдах гэмт хэрэгт өртөх, хүчирхийлэл, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргүүдийг зохих түвшинд гүйцэтгэхдээ албаны хэрэгцээнд галт зэвсэг эзэмших, ашиглах шаардлага зүй ёсоор тавигдах нь ойлгомжтой билээ.

Батлан хамгаалах, Хууль сахиулах салбарын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч алба хаагч нь Үндэсний аюулгүй байдлыг хангах болон иргэдийн эрх чөлөө, эрүүл мэнд, амь насыг гэмт халдлагаас хамгаалахад хуулийн хүрээнд, үйл ажиллагаагаа осол аюулгүй явуулах өндөр шаардлага тавьдаг учир тэдгээрийн ур чадварыг дээшлүүлэх, байнгын бэлэн байдлыг хангуулах хэрэгцээгээ дагаад их өндөр зардал гаргах болдог байна. Гэвч тухайн салбарын төсөв улс орны төсөвт ихээр төсөвлөгдсөн мэт харагддаг тул иргэд, олон нийт, бусад салбарын зүгээс аль болох төсөв, санхүү, зардлыг бууруулах, танах талаар үргэлж ярьж байдаг нь нууц биш юм.

Алба хаагч нэг бүрд галт зэвсгийг ашиглах, эзэмших, хадгалах, хамгаалах талаарх хууль, эрх зүйн актын тухай онол, арга зүйн болон галт зэвсэг ашиглах шаардлага гарсан үед хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх чадвартай, мэдлэгтэй байх, ямар арга хэмжээ авах талаар бүрэн мэдлэг олгох системтэй сургалтыг өдөр бүр явуулж байх нь чухал байна.

Дээрх онол арга зүйн сургалттай уялдуулан галт зэвсгийг ашиглах практик дадлага сургалтыг олон улсын жишиг болон өөрийн орон, монгол хүний зан, төлөвийн онцлогт тааруулан үр дүнтэй явуулах нь чухал юм.

⁴ Монгол Улсын хууль “Галт зэвсгийн тухай” 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдөр, Улаанбаатар хот. 4 дүгээр зүйл.

Манай хөрш улсууд болон бусад улс орнууд Зэвсэгт хүчин, хууль сахиулах салбарын шинэчлэлийн хүрээнд буудлагын зэвсгийн сургалт бэлтгэлээ өөрчлөн шинэчилж шинжлэх ухаан, практик туршлагатай хослуулан явуулж байна.

БНХАУ-ын Ардын чөлөөлөх армийн цэрэг эрс буудлагын бэлтгэл хийхдээ бай болгож дуулгатай цэргийн толгой дээр тавьсан алим жимсийг бууддаг болжээ. Ийм нэгэн буудлагын бичлэг цахим сүлжээнд тавигдсанаар цэргийн алба хаахаар хүүхдүүдээ явуулсан эцэг, эхчүүдийн зүгээс түгшүүртэй байдлыг үүсгэж, шүүмжлэл гомдлыг илүү гаргах болгосон байдаг. Гэвч Буудлагын зааварлагчийн өгүүлснээр бол ийм буудлага нь алдаа хийх эрхгүй болгодог төдийгүй цэргийн алба хаагчийг маш сайн төвлөрүүлэхэд хүргэдэг аж. Буудуулж байгаа цэрэг ч тэсвэр хатуужилтай болдог гэдгийг зааварлагч офицерууд хэлж байгаа юм. Буудлагын зэвсгийн сургалт бэлтгэлийн чанар үр дүнд анхаарч байгаа нь бидний хувьд ч дагаж хөгжихөөс өөр аргагүй юм⁵.

Аль ч улс орон өөрийн гадаад, дотоод аюулгүй байдлаа хангахдаа Батлан хамгаалах, Хууль сахиулах байгууллагууд нь мэргэшсэн, чадварлаг алба хаагчидтай байлгаж, тэдгээрийг сургаж бэлтгэн, ур чадвар, мэдлэг, ёс зүйг дээшлүүлж, байнгын бэлэн байдлыг хангах, аюулгүй байдал, нийгмийн хамгааллыг анхаарах нь төрийн үүрэг болсонтой уялдаж байдаг.

Галт зэвсгийн ашиглах ур чадвар хангалтгүйгээс болж тэдгээр алба хаагчдын дунд буу алдах, осол гэмтэл гарах, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хохироосон алдаа дутагдал, осол эндэгдэл гарч байсан билээ. Энэ гашуун сургамжаас болоод удирдах алба хаагчид тухайн галт зэвсэг хариуцсан албан тушаалтан аль болох галт зэвсгийг алба хаагчдадаа эзэмших ашиглах, нөхцөл боломжийг хааж, сейф савандаа л байвал аюулгүй гэж ойлгон, хадгалдаг жишиг одоог хүртэл зарим салбарт байсаар л байна.

Үүнийг өөрчлөх хэрэгтэй бөгөөд алба хаагч бүрт сургалт бэлтгэлийг зөв хийлгэж, сахилга баттай болгох нь нэн чухал юм.

Спортын буудлага болох практик буудлагад “Энэ спортоор хичээллэснээр санамсар болгоомжгүй үйлдлээс сум алдаж амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлж сурна. Тус спорт нь хагас зууны турш дэлхийн олон оронд хөгжихдөө санамсаргүй алдаа эндэгдлийн нэг ч тохиолдол гаргаагүй нь дэг журам, аюулгүй байдалд хамгийн сайн сургадаг хатуу чанд спортын төрөл гэдгээ тодорхой илтгэдэг юм”⁶ гэж байгаа нь буудлагын зэвсгийг зөв ашиглаж сурах, дадлага хийх нь ямар ач холбогдолтойг хэлж байна.

Галт зэвсэг ашиглах ур чадвар дутуугаас болж алба хаагч өөрт

⁵ www.wikimon.mn

⁶ <https://ipsc.mn>

хуулиар хүлээлгэсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болох, гэмт этгээдийг аюулгүй болгох, өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндийг хамгаалж чадахгүйд хүрч болох бөгөөд ингэснээр өөрөө алба хаагчийн аюулгүй байдал хангагдахгүйд хүрэх болно. Тухайлбал, хутгатай этгээд хүн барьцаалж хоолойд нь хутга тулган амь насанд халдахаар заналхийлсэн тохиолдолд алба хаагч галт зэвсэг ашиглан гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох шаардлага үүсэхэд галт зэвсэг ашиглах ур чадвар дутуугаас алдаа гаргаж барьцаанд байгаа иргэний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулбал алба хаагч мөрдөн шалгалтын явцад эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэл үүсэж болох юм.

Мөн хууль эрх зүйн мэдлэг, ур чадвар дутмагаас галт зэвсгээ ашиглаж чадахгүй, үүргээ биелүүлэх эргэлзээ төрж, буруудчих болов уу гэсэн сэтгэгдэл төрж үүний улмаас гэмт этгээдэд боломж гарган иргэний амь нас, эрүүл мэнд хохирч, өөрт нь аюултай нөхцөл байдал үүсэж болох юм. Үүнийг дагаад мөн адил хууль, тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний актаар хариуцлага тооцогдох эрсдэлд хүргэж болзошгүй юм.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагч галт зэвсэг ашиглах буудлагын сургалт бэлтгэлгүй, ур чадваргүй байх нь үүрэг гүйцэтгэх үедээ алдаа дутагдал гаргаж болох бөгөөд “сургалт бэлтгэлийн чанар, мэдлэг туршлага зэргээс хамаарах аюулгүй байдал”-д шууд нөлөөлнө гэж үзэж байна.

Галт зэвсэг ашиглах, хадгалах, хамгаалах, авч явах хууль эрх зүйн мэдлэг бүрэн эзэмшсэн, галт зэвсгийг өөрийн болгон ашиглаж сурсан байх нь санамсар болгоомжгүй алдаа дутагдал гаргахгүй, үүрэг гүйцэтгэх үедээ итгэл төгс ашиглах итгэл үнэмшилтэй болгох бөгөөд алба хаагчийн аюулгүй байдал нэг талаараа бүрэн хангагдаж байгаа гэсэн үг юм.

Тэгэхээр өгч байгаа төсвийн хөрөнгийг үр ашигтай алба хаагчдадаа хүртээмжтэй хүргэхийн тулд буудлагын цахим орчныг байгууллага, албандаа авч ашиглах, шинээр гарч ирсэн техник, технологийг шуурхай нэвтрүүлэх нь чухал асуудал болоод байна.

Хоёр. Галт зэвсэг ашиглах сургалтыг сайжруулах арга зам

Төрийн цэргийн болон Хууль сахиулах салбарын алба хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүргийн нэг болох галт зэвсгийг хэрхэн зөв ашиглаж, аюулыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх бөгөөд оновчтой зөв буудах арга барилыг суулгахын тулд буудлагын ур чадварыг дээшлүүлэх, байнгын бэлтгэл сургалт хэрэгтэй байдаг. Буудлага спортын нэг төрөл болох практик буудлагын анхлан суралцаж байгаа буудагч тамирчны сургалт бэлтгэлийн зардал нь хамгийн багадаа 800 ширхэг сум түүнээс илүүг зарцуулж буудлага хийх сэтгэлзүй суудаг гэсэн практик судалгаа байна.

Алба хаагчдын буудлагын сургалтыг сайжруулах дараах арга, хэрэгсэл, орчин нөхцөл бий болгох хэрэгцээ байна. Үүнд:

- Будган сумтай буу;
- Интерактив программтай буудлагын тир, тоног төхөөрөмж;
- Дотоод буудлагын байр;
- Тактикийн болон бусад бэлтгэлтэй хамт явуулах гадна, дотор буудлагын талбай.

Дээрх арга хэрэгслийн нэг болох интерактив программтай буудлагын тир, тоног төхөөрөмж нь хүний аюулгүй байдлыг хангах чиглэлийн нэг болох “Технологид нэвтрэх” асуудал нь хүний туршлагыг сайжруулж, бага зардлаар ихийг хийх боломжийг бидэнд олгох⁷ бөгөөд үүнийг энэ салбарт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Батлан хамгаалах, Хууль сахиулах алба хаагчдын сургалт бэлтгэлийг чанаржуулах, мэргэжлийн болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор галт зэвсгийг цахим орчинтой уялдуулж бодит мэт буудлагын орчин, нөхцөлийг бий болгох, галт зэвсгээр буудлагын сургалт хийх, дадлага сургалтын орчныг технологийн компаниуд хөгжүүлсээр байна.

Буудлагын цахим орчныг ерөнхийд нь гурав ангилж болох юм.

1. Спорт буудлагын программ;
2. Сонирхогчийн практик буудлага, айрсофт буудлагын программ;
3. Батлан хамгаалах, Хууль сахиулах салбарт зориулсан программ.

Спорт буудлагын программ: Энэ программ нь олимп, дэлхий, олон улсын хэмжээнд буудлага спортын төрөлд оролцох тамирчдыг бэлтгэх, тэдгээрийн буудлага үйлдэх үеийн алдааг шалгах, засах, шагайврын дасгал хийхэд чухал үр дүнтэй программ хангамж техник хэрэгсэл юм.

Сонирхогчийн практик буудлага, айрсофт буудлагын программ: Энэ төрлийн программ хангамж иргэдийн галт зэвсэг эзэмшихэд дадлага болох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд зориулагдсан, хийн буу болон практик буудлагын спортод зориулсан программ, техник хэрэгсэлтэй байдаг. Энэ төрлийн программ хангамж нь хөдөлгөөн дундаа буудлага үйлдэх, хөдөлгөөнт бай буудах зэргээрээ спорт буудлагын программ хангамжаас ялгаатай байдаг.

Батлан хамгаалах, хууль сахиулах салбарт зориулсан программ: энэ программ бол батлан хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, террорист үйлдлийн сөрөх тусгай ажиллагааны үед галт зэвсгийг чадамгай ашиглаж өгөгдсөн үүргийг амжилттай гүйцэтгэх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төрлийн галт зэвсгийн буудлагыг үйлдэх, жинхэнэ сумтай болон сумгүйгээр сургалт дадлага хийх, бодит мэт барьцаалагдсан хүн, объект чөлөөлөх, бүх

⁷ <https://humansecurity.world/what-is-human-security/>

төрлийн орчинд үүрэг гүйцэтгэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх бололцоог бүрдүүлж өгсөн байдгаараа онцлогтой юм.

Цахим буудлагын орчны давуу тал:

- Чиг үүрэг, ажлын онцлогоос хамаарах орчин нөхцөл, галт зэвсгээ ашиглан сургалт дадлага хийж болох давуу талтай, суманд зарцуулагдах зардлаа хэмнэх боломжтой.
- Аюулгүй байдлын хувьд ихэнх тохиолдолд лазер мэдрэгчийг ашигладаг тул аюулгүй ажиллагаанд санаа зовох зүйлгүй байдаг. Зарим цахим буудлагын орчныг жинхэнэ сумаар буудахаар тоногловсон нь бодит буудлага хийхтэй адил аюулгүй ажиллагааны дүрмээр сургалт хийгддэг.
- Бүх төрлийн байг ашиглах, ердийн цаасан бай, электрон байг ашиглаж болдог.
- Тухайн программ хангамжид нэмэлт орчин нөхцөлийг бий болгох, олон төрлийн хэрэгслийг нэмж суурилуулж болох давуу талтай юм.
- IR инфра туяа болон улаан лазер ашиглах нь бодит байдалд өдрийн нөхцөлд буудлага үйлдэж байгаа мэт орчин үүсгэдэг.
- Алба хаагч өөрийн эзэмшлийн галт зэвсэг ашиглах нь жин, хэмжээ, гохны даралт, тийрэлт зэрэг өгөгдлийг өөрийн болгож эзэмших нь дараа нь бодит буудлага үйлдэхэд адил байх боломжийг бүрдүүлж өгдөг.
- Албанд ашиглах сумыг хэмнэх бөгөөд цахим буудлагын орчинд IR инфра туяа болон улаан лазераар буудлага үйлдэх бүрд өндөр зардал гаргахгүй юм.
- Сургалтыг хаана ч, хэдийд ч хийж болох бөгөөд албан өрөө, сургалтын танхим, гэртээ хийсэн ч болох юм.
- Бүх төрлийн галт зэвсэгт тааруулж болох нэмэлт хэрэгсэлтэй байдаг.

Цахим буудлагын орчны сул тал:

- Бодит буудлага биш гэсэн сэтгэхүй үүсвэл бодит буудлага үйлдэх үед аюулгүй байдал алдагдаж болно. Тодорхой хугацаанд сургалт явуулсны дараа бодит буудлага заавал хийж байх.
- Программ, техник хангамж ашиглах учир алба хаагч энэ талын мэдлэгтэй байх шаардлагатай.
- Цахим буудлагын орчин зөвхөн буудлага хийх арга барилаа алдахгүй байх оновчтой буудах аргаа сайжруулах хэрэгсэл тул байнга хэрэглэх хэрэгтэй. Төсөв хэмнэж буудлагын дадлага сургалтыг хэт их цахим болговол бодит нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэхэд хүндрэл гарч болох талтай.
- Өрөө тасалгаа орчин хязгаарлагдмал, алба хаагч бие бялдрын болон сэтгэлзүйн ачаалал дарамт бага ирэх нь сул талыг бий болгож байдаг.

Галт зэвсэг ашиглан бодит буудлага үйлдэх нь бие бялдар, сэтгэлзүйн бэлтгэл болж байдаг гэж үздэг.

Дүгнэлт

Батлан хамгаалах, Хууль сахиулах байгууллагын галт зэвсэг ашиглах, буудлагын сургалт бэлтгэл дутуу, үр дүнгүй явуулснаар алба хаагч нь үүрэг гүйцэтгэх үедээ алдаа дутагдал гаргаж болох бөгөөд “сургалт бэлтгэлийн чанар, мэдлэг туршлага зэргээс хамаарах аюулгүй байдал”-д шууд нөлөөлөх учир буудлагын дадлага сургалтыг сахилга баттай, чанартай, олон удаагийн давтамжтай өдөр тутам хийх нь галт зэвсгийг өөрийн болгож алба хаагчийн ур чадварыг дээшлүүлж алдаа дутагдалгүй үүрэг гүйцэтгэх боломжийг хангаж алба хаагчийн аюулгүй байдлыг хангах;

Монгол улсын галт зэвсэг ашиглах, эзэмших, хууль эрх зүйн актын талаар бүрэн мэдлэгтэй болгох хялбаршуулсан сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гаргаж алба хаагч болон сонсогч нэг бүрд чанартай хүргэх;

Батлан хамгаалах, Хууль сахиулах байгууллагад технологийн шийдлүүдийн нэг хэлбэр болох буудлагын цахим орчныг нэвтрүүлэх; (буудлагын сургалтад зарцуулах төсөв болон сум, галт хэрэглэлийг үр ашигтай зарцуулах болно).

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, арга зүйг гадаад, дотоодын тэргүүн туршлага дээр боловсруулан хийж дадлагажуулж байх;

Буудлагын цахим орчныг албан өрөөндөө, хичээлийн танхимд, гэртээ буудлагын дадлага хийх нь галт зэвсгийг өөрийн бие эрхтний нэг хэсэг мэт болгож байгаа нь алба хаагчийн ур чадвар дээшлүүлж алдаа дутагдалгүй үүрэг гүйцэтгэх боломжийг хангаж өгөх хэрэгтэй юм.

Эшлэл авсан эх сурвалжийн жагсаалт

1. А.Хүү-Ухна “Зэвсэглэлийн түүх, орчин үе, хэтийн төлөв” Улаанбаатар 2015 он.
2. Монгол Улсын хууль “Галт зэвсгийн тухай” 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдөр, Улаанбаатар хот. 4 дүгээр зүйл.
3. Монгол улсын үндсэн хууль 1992 он
4. Ч.Улаанхүү “Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал”, Улаанбаатар хот ЭКИМТО хэвлэх үйлдвэр 2014 он хуудас 256
5. Профессор Ж.Бор, дэд профессор В.Чулуунбат “Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс”, Улаанбаатар хот 2012 он хуудас 306
6. Ч.Улаанхүү “Аюулгүй байдлын үндэс”, Улаанбаатар хот “Шидэт өнгө” хэвлэх үйлдвэр 2016 он хуудас 364
7. Хүний аюулгүй байдал 2009 он
8. Монгол улсын хууль “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 2008 оны 05 сарын 22 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

9. Монгол улсын их хурлын тогтоол 2015 оны 10 сарын 08 өдөр Дугаар 85 “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай” Улаанбаатар хот
10. “Teachers’ Guide for Military Technology” 2001-11-26: 1. Retrieved 2014-11-20.
11. The Human Security Index: An Update and a New Release David A. Hastings
12. Хүний аюулгүй байдал эмхэтгэл 2011 он
13. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл Улаанбаатар 2016 он. Хууль сахиулахын их сургууль